



ӨНӨӨГИЙН МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШНЫ БАЙДАЛ

Илтгэгч: Д.Нямсамбуу, Гавж

Гандантэгчэнлин хийдийн гүн ухааны багш,
MSc in Buddhist Studies, University of Sunderland, UK

Бурханы шашны сургаалийн үндэс юунд оршдог вэ?

Үнэндээ шашин бүр л ёс зүйг номлож, нийгэм хийгээд хувь хүний ёс суртахуунд эерэгээр нөлөөлдөг билээ. Энэ эерэг нөлөөний хүчээр ёс суртахууний гайхам өндөр түвшинд хүрсэн хүмүүсийн жишээ шашин бурт нэн олон. Гэвч яагаад тэр мэт сайн үйлийг бүтээж муу үйлээс зайлсхийх ёстойг өөр өөрсдийн ертөнцийг үзэх үзлийн үүднээс ялгаатайгаар тайлбарлах нь бий. Зарим, магадгүй дийлэнх шашнуудийн? сайн сайханд уриалан дуудахдаа далдын хүч, агуу эзэн тэнгэрийг ашигладаг бөгөөд тэдний хувьд ёс суртахуун гэдэг нь ертөнцийг бүтээгч /эзэн тэнгэрийн бидэнд өгсөн хэм хэмжээ, тушаал учир түүнийг даган мөрдснөөр их эзний аврал ивээлд багтах аж.


Харин Бурханы шашин ертөнцийг үүсгэн, юмсийн зөв бурууг тогтоогч, гагц түүнд итгэн сүсэглэснээр аврагдах 'Эзэн'-г хүлээн зөвшөөрдөггүй тул ёс зүйн хэм хэмжээ, чухам яагаад түүнийг сахин мөрдөх ёстойг хэрхэн үзсэн нь сонин юм. Тодруулбал, шүтэн барилдлагын онол, түүний нэгээхэн хэсэг болсон үйлийн үрийн онол үүний хариултыг өгдөг тул 'үйлийн үрийн онол'-ийн талаарх мэдлэг, итгэл үнэмшил гэдэг Буддын шашинтнуудын хувьд сайнд тэмүүлэх, муу бүгдээс зайлсхийх, сайн мууг ялган салгах гол суурь нь болох учиртай. Буддизмын амин сүнс нь болсон энэ онолыг ерөнхийд нь тайлбарлавал:

Бусдаас үл хамааран оршин тогтнох нэг ч зүйл үгүй бөгөөд үнэндээ алив зүйлийн оршин тогтнох цор ганц боломж нь бусдад дулдуйдах, бусдаас хамаарах хамаарал юм. Хувь хүн, түүний амар амгалан ч өөрийгөө хүрээлэгч сав хийгээд шим ертөнцөөс хамааран бий болох бөгөөд хүлээн авагч хүний хувьд бусдаас ирэх таатай хийгээд таагүй нөлөө нь өмнө хувь хүний бусдад хэрхэн хандсан хандлага, илгээлтийн шууд үр дүн юм. Энэ зүй тогтол нь хэний ч бүтээл биш бөгөөд харин нийгэм, ер алив байгууллын гишүүдийн оршин тогтнох тэмүүллийн хүрээнд, тэдний хооронд гарцаагүй бий болдог харилцан нөлөөлөл, үйлчилцэл юм. Энэ харилцан хамаарлыг үл тоомсорлох, үл анзаарах, ганц дан өөрийхөө эрх ашгийг тооцон түүний хойноос хөөцөлдөх аваас тэр хувь зүйл цаашид тэр мэт оршин тогтнох боломжгүй болно гэж энэ шашин үздэг байна. Ийм ч учраас нүгэл буян гэдэг бидний Бурхан, Эзэн тэнгэрийн өмнө хүлээсэн үүрэг биш, харин бусдынхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлага юм. Алив үйлдлийг 'нүгэл' хэмээн яллагч нь ч 'Эзэн тэнгэр' биш, уг үйлийн үр дүнд хэн нэгэнд гарсан хохирол, зөрчигдсэн эрх юм. Энэ утгаараа ардчилсан нийгмийн хүмүүний эрх, түүний хэм хэмжээний ойлголттой нэн дүйцэж харагдана.

Харин өнөөдөр энэ сургаал, энэ шашны мөн чанарын талаар Монголчууд маань хэр зэрэг мэдлэг, мэдээлэлтэй байна вэ?


Ардчилсан хувьсгал ялж, бид шүтэх бишрэх эрхээ олж авсанаас хойш 20 шахуу жил өнгөрч байх энэ үед Монголын Бурханы шашин маань хаана хүрсэн байна зэрэгт дүгнэлт өгөх үүднээс Монголын Бурхан Шашинт Оюутны Холбооноос (МБШБХ) 2008 оны 10-р сараас эхлэн хийгдсэн судалгааны зарим үр дүнг танилцуулья.

Судалгаанд нийслэлийн улсын болон хувийн их дээд сургуулиудын 1950 оюутан хамрагдсанаас 77% нь өөрсдийгөө яамар нэгэн байдлаар шашин шүтдэг, харин 22% нь шашин шүтдэггүй гэж хариулжээ. Шашин шүтдэг хэмээн хариулсан оролцогчдын 83% нь Бурханы шашин, 11% нь Христ, 3% нь Ислам мөн 3% нь бөө мөргөлийг шүтдэг байна. Бурханы шашин шүтдэг 1252 оюутнаас уг шашныг шүтэх болсон шалтгааныг тодруулахад:



Үүнээс харахад Бурханы шашинт залуусын тэн хагас нь гэр бүлийнхэн нь шүтдэг болон уламжлалт гэсэн утгаар Буддын шашнаа сонгосон бол Христэд итгэгч оюутан залуусийн ердөө таван хувь гэр бүлийн нөлөөгөөр шашиндаа орсон байна.

Христийн шашин шүтэгчдийг авч үзвэл



Хэдийгээр 70-н жилийн туршид явагдсан шашны эсрэг (үнэндээ ердөө Буддын Шашны л эсрэг) үзэл суртлын кампанит ажлын дараа өдий олон залуусын зүрх сэтгэлд Бурханы шашин ойр дотно хэвээр байгаа нь Монголчууд бидний сэтгэлд эл шашин хэр гүнзгий хоногшин тогтосныг илтгэх болов ч нөгөөтэйгүүр уламжлалт болон эцэг өвгөд шүтэж ирсэн гэх төдий нь алив шашинд итгэж үнэмших дорвитой чимбай шалтгаан болж чадахгүй юм. Бурханы шашны гайхамшиг нь түүний номлол сургаалдаа байх, түүнийг таниж мэдсэний үндсэн дээр төрөх итгэл үнэмшилийг жинхэнэ итгэл мөн харин үнэн зөвийг эргэцүүлэлгүй, сохроор бишрэн сүсэглэхийг мунхаг зүйл хэмээн Буддын олон ном сударт тодорхой өгүүлсэн байдаг. Гэтэл өнөөдөр Бурханы шашинд итгэгчдийн маань дийлэнх нь өөрсдийн шашнаа мэдлэгийн хүрээ тэлэн, ёс суртахуун төлөвших хүчин зүйл болгон үзэлгүй далдын алив нэгэн муу зүйлээс хамгаалах дом төдий хүлээн авч байгаа нь Б.Оюун-Эрдэнийн ‘Монголын Бурханы шашны өнөөгийн нөхцөл байдал, түүнийг шинэчлэх асуудал’ сэдвээр докторын зэрэг хамгаалсан бүтээлээс тодорхой харагдаж байна. Энэ судалгаагаар бурханы шашинтнуудын маань ердөө 10% нь бурханы шашин шүтсэний үр дүнд мэдлэг боловсрол дээшлэнэ, 13% нь ёс суртахуун төлөвшинэ гэж үздэгийг илрүүлсэн байна.

Тэгвэл Буддийн шашны талаар үнэн зөв мэдээллийг нийтэд хүртээн түгээх, ялангуяа Буддист ёс суртахуун, хүмүүжлийг нийтэд олгох тал дээр сүм хийдүүд маань юу хийж байна, мөн юуг хийх хэрэгтэй байна вэ?

Үүнд бас МБШБХ судалгааны хэдэн баримтыг дурьдах хэрэгтэй болов уу. Өөрсдийн шашны хэр сайн мэдээлэл авдаг талаар залуусын сонгосон хариултыг үзвэл:

Бурханы шашинтны хувьд:

| маш их | сайн | дунд | муу | огт үгүй | татгалзсан |
|--------|------|------|-----|----------|------------|
| 7% | 31% | 47% | 12% | 1% | 2% |

Христийн шашинтны хувьд:

| маш их | сайн | дунд | муу | огт үгүй | татгалзсан |
|--------|------|------|-----|----------|------------|
| 36% | 38% | 17% | 5% | 2% | 2% |

Б. Оюун-Эрдэнийн судалгаагаар Бурханы шашинд итгэгчдийн 31,9% нь өнөөгийн шашны байдалдаа сэтгэл хангалуун, 68,1% нь дундуур байдаг бол Христийн шашинтнуудийн 76,9% сэтгэл хангалуун, 10,1% нь сэтгэл дундуур байдаг гэж гарсан байна. Товчдоо Буддын шашны сүм хийдүүдээс сүсэгтэн олондоо хүрсэн үйл ажиллагаа дулимаг, хангалтгүй хийдэг болох нь харагдаж байгаа боловч цаг хугацааны хувьд хамгийн сүүлд хийгдсэн Б.Ш.О.Холбооны судалгаанд нийт оролцогчдоос Бурханы шашны өнөөгийн байдал буюу оршин тогтож байгаа байдлыг тодруулахад 49% нь уламжлалт шашин, 15% нь уламжлалт ч бэлэгдлийн чанартай, 12% ном унших төдий л оршдог, 17% нь уламжлалт ч сэргэж байгаа шашин хэмээн хариулсаныг үзвэл харьцангуй удаан хугацаа шаардагддаг Буддын шашны боловсон хүчин бэлтгэх бүтэц сэргэж сүүлийн нэг хоёр жилээс, сүм хийдүүдийн зүгээс явуулах үйл ажиллагаа идэвхижсэний шинж харагдана. Тухайлбал Буддын шашины чиглэлээр хийгдсэн маш олон тооны ном товхимлууд гарч байгаа, Буддын Соёлын Төвүүд энгийн сүсэгтэнүүдэд зориулсан Бурханы шашны хичээл эрдэмтэн лам нарын оролцоотойгоор байнга явуулж байгаа мөн Гандантэгчинлэн болон Зүүн Хүрээ хийдүүд амралтын өдрүүдэд Бурханы сургаалыг тайлбарласан хичээл байнга тогтмол явуулж байгаа зэргийг дурьдаж болох бөгөөд үр дүн нь ч туйлын өндөр байгаа юм.

Бурханы шашны байгууллагууд юу хийх шаардлагатай байна вэ? гэсэн асуултанд дараах хариулт өгснийг харахад Бурханы шашныг нээлттэй, ил тод таниулан сурталчилах, иргэдтэйгээ холбоотой ажиллахыг илүү илэрхийлсэн байна.

| | |
|-------------------------------------|-------|
| хүмүүнлэгийн ажил | - 17% |
| сурталчлах | - 24% |
| хүртээмжтэй цар хүрээтэй ажиллах | - 15% |
| мөнгөгүй болгох | - 7% |
| түгээн дэлгэрүүлэх | - 7% |
| христийг арилгах | - 2% |
| хүүхэд залууст | - 5% |
| нийгмийн тулгамдсан асуудалд чиглэх | - 7% |
| бусад | - 16% |

Энд миний ажигласан нэг зүйл бол Монголын Бурхан Шашинтны Төв Гандантэгчинлэн хийдийн зүгээс хүмүүнлэгийн үйл ажиллагаа нэлээд сайн явуулдаг, явуулж ирсэн боловч үүнийгээ сурталчилан таниулах тал дээр огт мэрийж хичээгээгүй байна. Тухайлбал 7 хоног тутам болдог захиргааны хурал дээр адаглаад 3-5 тусламж хүссэн хүмүүсийн өргөдөл орж ирдэг бөгөөд бараг бүгд тодорхой хэмжээгээр шийдэгддэг, Гандан өөрийн өнчин хүүхдийн цэцэрлэгтэй, эмзэг бүлгийн хүүхдүүдийг асран хүмүүжүүлэх хөтөлбөртэйг мэддэг хүн үнэндээ цөөн болов уу.

Мөн энд дурьдагдаагүй боловч Бурхан шашны байгууллагууд, ялангуяа Бурхан Шашинтны Төвийн зүгээс хойшлуулашгүй шийдэх ёстой нэгэн асуудал бол шашны нэрийг барин элдэв бусармаг үйлдэл гаргагчдыг цэгцлэх явдал юм. Энэ нь лам хуврагуудын эрдэм мэдлэг, сахилга бат, мөн цаашлаад Бурханы шашны нэрээр орж ирж буй (тооцоолоход бэрхтэй боловч жилдээ хамгийн багаар бодоход 4 тэрбум төгрөг буюу Гандангийн жилийн орлогоос 10 дахин их мөнгийг Монголчууд бид Бурханы шашны үйлд зарцуулдаг байна) мөнгөний урсгалыг эргээд Бурханы шашинд, ёс суртахууныг түгээн дэлгэрүүлэхэд буюу зөв зүйлд зарцуулах асуудал юм.

Дүгнэлт

1. Гандан болон бусад сүм хийдүүд сүсэгтэн олныхоо шашны мэдлэг, ёс суртахууныг дээшлүүлэх тал дээр чармайн ажиллах хэрэгтэй байна.
2. Хүмүүнлэгийн чиглэлээр явуулж буй үйл ажиллагаагаа илүү өргөжүүлэх мөн нийтэд таниулах, энэ талаар мэргэжсэн боловсон хүчнийг бэлтгэх.
3. Дотоод бүтцээ илүү боловсронгуй болгож лам нарын сахилга дэг журам, иргэний болон шашны мэдлэг боловсролыг сайжруулах.